



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/231

Хэрлэн сум

Орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага, сургалт зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 12 дугаар зүйлийн 11.1, 11.4.2, 22 дугаар зүйлийн 22.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/110 дугаар тушаал Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.15, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 4.2 дахь заалт, Цэргийн штабын 2024 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага сургалтыг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд Дадал сумын түшиглэн зохион байгуулсугай.

2.Сургалтыг зохион байгуулахад шаардлагатай 39,608,200 (гучин есөн сая зургаан зуун найман мянга хоёр зуун) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.


3.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

4.Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын 26 ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

Орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага, сургалт
зохион байгуулах зардал

д/д	Зардлын нэр	Төсөвлөсөн	Хянасан	Тайлбар
1	Хоолны зардал	16.380.000		
2	Томилолт, урамшууллын зардал	4.410.000		
3	Бичиг хэргийн зардал	925.000		
4	Шатахууны зардал	4.183.200		
5	Материал хэрэгслийн зардал	13.710.000		
Нийт дүн		39.608.200		

Нэг. Хоолны зардал

д/д	Сар өдөр	Хооллох хүний тоо	Хоол		Нийт үнэ	Тайлбар
			Өдөрт 1 удаа	Өдрийн 3 хоол		
1	6/05	130	6000	2.340.000	2.340.000	Сургалтад оролцогч 130 бэлтгэл үүрэгтэн өдөрт 3 удаа хооллох
2	6/06	130		2.340.000	2.340.000	
3	6/07	130		2.340.000	2.340.000	
4	6/08	130		2.340.000	2.340.000	
5	6/09	130		2.340.000	2.340.000	
6	6/10	130		2.340.000	2.340.000	
7	6/11	130		2.340.000	2.340.000	
Нийт дүн				16.380.000	16.380.000	

Хоёр. Томилолт, урамшууллын зардал

д/д	Ажиллах газар	Хүний тоо	Хоног	Хоногийн томилолт	Мөнгөн дүн
1	Дадал сум	7	7	90.000	4.410.000
Нийт					4.410.000

Гурав. Бичиг хэргийн зардал

д/д	Зардлын нэр	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Баннер 6*3 хэмжээтэй	2	20.000	720.000
2	Бичгийн цаас	5	20.000	100.000
3	Притерын хор цэнэглэх	2	10.000	20.000
4	Слайд	30	1000	30.000
5	Өнгийн хатуу цаас	30	1000	30.000
6	Баримт бичгийн нуруу	15	1000	15.000
7	Өнгийн харандаа	2	5000	10.000
Нийт дүн				925.000

Дөрөв. Шатахууны зардал /Аи92 2520/

д/д	Сумын нэр	Машины марк	Зарцуулах норм 100км/т	Тоо	Явах км	Зарцуулах шатахуун	Нийт үнэ
1	Дадал, Норовлин, Батноров сумдад ажиллах	Delica D5	18	1	1200	216	544.320
2		Пургон	18	1	1200	216	544.320
3		Пургон	18	1	800	144	362.880
4		Пургон	18	1	800	144	362.880
5		Зил-131	35	1	900	315	793.800
6		Зил-131	35	1	300	105	264.600
7	Улаанбаатараас Дадал сум,	Long-78	20	1	1300	260	655.200
8	Дадал сумаас Улаанбаатар	Long-78	20	1	1300	260	655.200
Нийт дүн				7		1660	4.183.200

Тав. Материал хэрэгслийн зардал

д/д	Материалын нэр	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Тусгай үүрэг гүйцэтгэх бүлгийн бүрэлдэхүүнийг тусгай зориулалтын хувцас өмд, китель, малгай, хантааз, өвдөгч, бээлий	25	258.400	6.460.000	
2	Аймгийн болон Дадал сумын газрын зураг хэвлүүлэх	2	125.000	250.000	
3	Хулдаасан хөлтэй самбар	6	70.000	420.000	
4	Хичээлийн цэгүүдийг төхөөрөмжлөх	Туг, олс, таних тэмдэг, г,м	1.000.000	1.000.000	
5	Арга хэмжээний үйл ажиллагааг сурталчилсан дүрс бичлэг	2 хүн	250.000	500.000	
6	Сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай хэрэгсэл	10	150.000	1.500.000	
7	БХЯ, ЗХЖШ-аас ирсэн зочдыг байрлуулах	15 хүн 5 хоног 6 өрөө	80.000	480.000	
8	Сум галт хэрэгсэл ТОЗ-8 сум	3 хайрцаг	200.000	600.000	
9	Сургалтын үйл ажиллагаатай холбоотой бусад зардал	1	2.500.000	2.500.000	
Нийт дүн				13.710.000	